

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/287/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024-02-25 № 4/147
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Э.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 7 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 80,6 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	155,606,788.66	121,494,698.06
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	112,805,526.66	80,680,489.06
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	112,805,526.66	80,680,489.06
31210	Төгрөг	112,805,526.66	80,680,489.06
31211	Төрийн сангийн харилцах	112,805,526.66	80,680,489.06
35	БАРАА МАТЕРИАЛ	42,801,262.00	40,814,209.00
35100	Түүхий эд материал	2,190,500.00	2,190,500.00
35110	Тусгай зориулалттай материал	2,190,500.00	2,190,500.00
35400	Хангамжийн материал	40,610,762.00	38,623,709.00
35410	Бичиг хэргийн материал	2,359,000.00	2,058,900.00
35420	Аж ахуйн материал	34,270,250.00	35,756,300.00
35460	Хүнсний материал	3,981,512.00	808,509.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	514,499,004.70	499,016,024.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	514,499,004.70	499,016,024.60
39200	Биет хөрөнгө	510,491,004.70	495,008,024.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	538,945,763.32	538,945,763.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	-49,830,455.80	-66,735,321.04
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	30,700,400.00	36,555,527.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-19,872,927.78	-25,981,182.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,036,313.69	24,434,455.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,337,694.26	-12,478,321.21
39209	Зам, гүүрийн байгууламж	659,436.80	659,436.80
39210	Хуримтлагдсан элэгдэл	-76,934.27	-659,436.80
39217	Ном	267,103.00	267,103.00
39300	Биет бус хөрөнгө	4,008,000.00	4,008,000.00
39301	Програм хангамж	100,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-100,000.00	-100,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,008,000.00	4,008,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	670,105,793.36	620,510,722.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	961,608.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	961,608.00
41300	Өглөг	0.00	961,608.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	961,608.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	670,105,793.36	619,549,114.66
51	Засгийн газрын хувь оролцоо	670,105,793.36	619,549,114.66
51100	Засгийн газрын оруулсан капитал	91,127,106.80	91,127,106.80
51100 2	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	91,127,106.80	91,127,106.80
51200	Хуримтлагдсан үр дүн	179,913,843.13	129,357,164.43
51210	Өмнөх үеийн үр дүн	-493,760,100.72	179,913,843.13
51220	Тайлант үеийн үр дүн	673,673,943.85	-50,556,678.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	399,064,843.43	399,064,843.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	670,105,793.36	620,510,722.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	973,115,789.72	333,013,769.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	577,302,762.90	9,758,269.00
120	Нийтлэг татварын бус орлого	577,302,762.90	9,758,269.00
12001 7	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	533,951,755.90	9,758,269.00
12001 8	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	43,351,007.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	395,813,026.82	323,255,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	342,984,700.00	282,071,700.00
13100 1	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	342,984,700.00	282,071,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,769,000.00	0.00
13110 4	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,769,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,059,326.82	41,183,800.00
13200 1	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,059,326.82	41,183,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	299,441,845.87	383,570,447.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	299,441,845.87	383,570,447.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	288,776,345.87	383,570,447.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	169,468,779.93	230,737,711.67
21010 1	Үндсэн цалин	135,690,691.89	182,967,054.59
21010 2	Нэмэгдэл	25,146,101.44	40,399,104.68
21010 4	Урамшуулал	8,631,986.60	7,371,552.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,339,848.74	28,521,933.93
21020 1	Тэтгэврийн даатгал	16,321,549.77	19,639,540.17
21020 2	Тэтгэмжийн даатгал	1,772,594.02	2,310,534.18
21020 3	ҮОМШӨ-ний даатгал	1,418,075.31	1,945,707.72
21020 4	Ажилгүйдлийн даатгал	347,455.14	437,126.87
21020 5	Эрүүл мэндийн даатгал	5,480,174.50	4,189,024.99

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,491,571.00	40,215,408.00
21030 1	Гэрэл, цахилгаан	2,244,195.00	3,691,944.13
21030 2	Түлш, халаалт	30,237,376.00	36,493,463.87
21030 3	Цэвэр, бохир ус	10,000.00	30,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	158,500.00	5,013,550.00
21040 1	Бичиг хэрэг	158,500.00	0.00
21040 2	Тээвэр, шатахуун	0.00	656,500.00
2105	Нормативт зардал	32,596,345.00	42,325,795.00
21050 1	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	234,000.00	560,600.00
21050 2	Хоол, хүнс	32,123,845.00	41,765,195.00
21050 3	Нормын хувцас, зөөлөн эдлэл	238,500.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	890,000.00	1,522,000.00
21060 1	Багаж, техник, хэрэгсэл	0.00	22,000.00
21060 4	Урсгал засвар	890,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	474,000.00	675,000.00
21080 6	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	474,000.00	675,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,357,301.20	34,559,049.10
21090 1	Бараа үйлчилгээний бусад зардал	4,449,650.00	5,471,500.00
21090 2	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	654,900.00	2,351,300.00
21090 3	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,252,751.20	26,736,249.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,665,500.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,665,500.00	0.00
21320 8	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	10,665,500.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	673,673,943.85	-50,556,678.70
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	673,673,943.85	-50,556,678.70

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	395,813,026.82	323,255,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	395,813,026.82	323,255,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	342,984,700.00	282,071,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	342,984,700.00	282,071,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,769,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчил хуваарилсан хөрөнгө	10,769,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,059,326.82	41,183,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,059,326.82	41,183,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	280,207,500.16	353,885,537.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	280,207,500.16	353,885,537.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	269,542,000.16	353,885,537.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	164,108,379.36	222,131,945.60
210101	Үндсэн цалин	130,643,840.52	170,801,351.21
210102	Нэмэгдэл	24,730,693.96	42,807,656.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	8,733,844.88	8,522,937.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,268,399.80	37,127,700.00
210201	Тэтгэврийн даатгал	23,153,999.80	25,246,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,718,600.00	2,970,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,414,900.00	2,376,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	543,700.00	593,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,437,200.00	5,940,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,491,571.00	39,683,800.00
210301	Гэрэл, цахилгаан	2,244,195.00	4,121,944.13

21030 2	Түлш, халаалт	30,237,376.00	35,531,855.87
21030 3	Цэвэр, бохир ус	10,000.00	30,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	0.00
21040 1	Бичиг хэрэг	103,500.00	0.00
2105	Нормативт зардал	28,153,250.00	38,592,192.00
21050 2	Хоол, хүнс	28,153,250.00	38,592,192.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	890,000.00	1,500,000.00
21060 4	Урсгал засвар	890,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	624,000.00	675,000.00
21080 6	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	624,000.00	675,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,902,900.00	14,174,900.00
21090 1	Бараа үйлчилгээний бусад зардал	7,152,900.00	11,983,700.00
21090 2	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,750,000.00	2,191,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,665,500.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,665,500.00	0.00
21320 8	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	10,665,500.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	115,605,526.66	-30,630,037.60
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,800,000.00	1,495,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,800,000.00	1,495,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,800,000.00	1,495,000.00
22510 6	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,800,000.00	1,495,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,800,000.00	-1,495,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	112,805,526.66	-32,125,037.60
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	112,805,526.66
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	112,805,526.66	80,680,489.06

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	91,127,106.80	399,064,843.43	-493,760,100.72	-3,568,150.49
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	-493,760,100.72	-3,568,150.49
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	673,673,943.85	673,673,943.85
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	179,913,843.13	670,105,793.36
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	179,913,843.13	670,105,793.36
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	179,913,843.13	670,105,793.36
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-50,556,678.70	-50,556,678.70
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	129,357,164.43	619,549,114.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	394,877,300.00	314,196,737.60	80,680,562.40	79.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	394,877,300.00	314,196,737.60	80,680,562.40	79.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,877,300.00	314,196,737.60	80,680,562.40	79.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	289,989,800.00	222,131,945.60	67,857,854.40	76.6
210101	Үндсэн цалин	198,027,600.00	170,801,351.21	27,226,248.79	86.3
210102	Нэмэгдэл	83,317,500.00	42,807,656.74	40,509,843.26	51.4
210104	Урамшуулал	8,644,700.00	8,522,937.65	121,762.35	98.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,832,800.00	37,127,700.00	705,100.00	98.1
210201	Тэтгэврийн даатгал	25,725,900.00	25,246,400.00	479,500.00	98.1
210202	Тэтгэмжийн даатгал	3,026,500.00	2,970,100.00	56,400.00	98.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,422,000.00	2,376,900.00	45,100.00	98.1

21020 4	Ажилгүйдлийн даатгал	605,200.00	593,900.00	11,300.00	98.1
21020 5	Эрүүл мэндийн даатгал	6,053,200.00	5,940,400.00	112,800.00	98.1
2105	Нормативт зардал	50,385,100.00	38,592,192.00	11,792,908.00	76.6
21050 2	Хоол, хүнс	50,385,100.00	38,592,192.00	11,792,908.00	76.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	730,400.00	675,000.00	55,400.00	92.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,939,200.00	15,669,900.00	269,300.00	98.3
21090 1	Бараа үйлчилгээний бусад зардал	13,748,000.00	13,478,700.00	269,300.00	98.0
21090 2	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,191,200.00	2,191,200.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	394,877,300.00	282,071,700.00	112,805,600.00	71.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	282,071,700.00	282,071,700.00	0.00	100.0
31000 1	Улсын төсвөөс санхүүжих	282,071,700.00	282,071,700.00	0.00	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	112,805,600.00	0.00	112,805,600.00	0.0
35000 3	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	112,805,600.00	0.00	112,805,600.00	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүй хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оныг "Хамтын оролцоо үнэлгээний үр дүнд суурилсан менежментийг сайжруулах" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 7 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 79.6 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус цэцэрлэг нь 15 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,

- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд
- Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал,заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 он 11 сард аймгийн засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдсан. 91,9 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 49,595.7 мянган төгрөгөөр буюу 5,1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	112,805.5	80,680.5	-32,125.04
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	42,801.2	40,814.2	-1,987.05
Үндсэн хөрөнгө	514,499.0	499,016.0	-15,483.0
Нийт хөрөнгө	670,105.8	620,510.7	-49,595.1
Өр төлбөр		961.6	961.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	670,105.8	619,549.1	-50,556.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	670,105.8	620,510.7	-49,595.1

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 80,680.4 мянган төгрөг болж өмнөх оноос 32,125.04 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн гүйцэтгэлийн зарцуулалт өссөнөөс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 1,987.0 мянган төгрөгөөр буурсан нь эхний үлдэгдлийн тооцоолол буруу татагдсан программын алдаанаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө данс 15,482.9 мянган төгрөгөөр буурсан нь Үндсэн хөрөнгийн элэгдлийг буруу тооцсон программын эхний үлдэгдэл зөрүүтэй татагдсанаас шалтгаалсан байна. Гэвч хандив болон тусламжаар хувь иргэнээс 4,746.3 мянган төгрөгийн хивс, телевизор, агаар цэвэршүүлэгч тоос сорогч зэрэг хөрөнгө, МАК компаниас иж бүрэн гэр 2 ширхэг 4,000.0 мянган төгрөгийн хөрөнгө орж ирсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 394,877.3 мянган төгрөг, орон нутгийн санхүүжилтээс 41,183.8 мянган төгрөг, нийт 436,061.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 436,061.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 436,061.1 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 436,061.1 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 273,012.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн санхүүжилтээр 41,183.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 314,196.7 төгрөг буюу 79,6 хувьтай байна

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605 Эрүүл мэндийг дэмжих	1,415.6	1,415.6		100%

2	81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	47,613.1	36,540.1	11,072.9	83,8%
3	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,344.9	3,344.9		100%
4	81823 Мэргэжил дээшлүүлэх	1,095.6	1,095.6		100%
5	81832 Нүүдлийн бүлэгт хамруулах	8,892.0	8,077.2	814.9	83,7%
6	81833 Явуулын багшийн үйлчилгээ	3,366.0	1,329.6	2,036.4	39,5%
7	81834 Боловсролын стандарт	258,778.6	212,032.9	46,745.6	81,9%
8	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	67,938.5	51,360.8	16,577.6	75,0%
9	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	41,183.8	41,183.8		100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	80111	1-12 сар	Үндсэн үйл ажиллагаа	Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал 100%	41,183.8	41,183.8
2	81605	9-12 сар	Үндсэн үйл ажиллагаа	Эрүүл мэндийг дэмжих 100%	1,415.6	1,415.6
3	81807	1-6, 9-12 сар	Үндсэн үйл ажиллагаа	Цэцэрлэгийн хүүхдийн хоол 83,8%	47,613.1	36,540.1
4	81816	1-6, 9-12 сар	Үндсэн үйл ажиллагаа	Хүүхдэд ээлтэй орчин 100%	3,344.9	3,344.9
5	81823	1-6, 9-12 сар	Үндсэн үйл ажиллагаа	Мэргэжил дээшлүүлэх 100%	1,095.6	1,095.6
6	81832	1-6,9-12 сар	Хүүхэд бүрийг хамруулах	Нүүдлийн бүлэгт хамруулах 83,67%	8,892.0	8,077.2

7	81833	6-8 сар	Хүртээмжтэй ажиллах	Явуулын багшийн үйлчилгээ 39,5%	3,366.0	1,329.6
8	81834	1-12 сар	Үндсэн үйл ажиллагаа	Стандарт сургалтын үйл ажиллагаа 81,9%	258,778.6	212,032.9
9	81835	1-12 сар	Үндсэн үйл ажиллагаа	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах 75%	67,938.5	51,360.8

Цэцэрлэгийн хүүхдийн хоол арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь сургуулийн хүүхдийн улирлын амралттай холбоотойгоор хүүхдийн ирц багасдагтай холбоотойгоор хэмнэгдсэн. Нүүдлийн бүлэгт хамруулах арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь орон тоо хэмнэсэн, хүүхдийн ирцтэй холбоотойгоор хэмнэгдсэн.

Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь томуу томуу төст өвчин ихэссэн, Ерөнхий боловсролын сургууль цахимд шилжсэнтэй холбоотойгоор хүүхдийн ирц буурч хэмнэгдсэн.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. Тендер зарласан боловч оролцох байгууллага байгаагүй учраас шууд худалдан авалтаар худалдан авалт хийсэн. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлуулж зохих хууль, журмын дагуу гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 02 дүгээр сарын 14-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 290.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 5,800.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,640.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг, авлагын үлдэгдэлгүй төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 67,857.8 мянган төгрөгөөр
- Нормативт зардлыг 11,793.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 150 мэдээллийг байршуулж 9 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3 “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулж, зөвлөмж өгсөн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх аудитаар өгсөн алдаа зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 2 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжээгүй байна гэж үзлээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	456.4	1	456.4	100%
Албан шаардлага	2	35,816.7	2	35,816.7	100%
Зөвлөмж	2	22,139.3	2	22,139.3	100%
Нийт дүн	5	58,412.4	1	58,412.4	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 80,738.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 80,738.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.2 Албан шаардлага

5.3 Зөвлөмж

1.Харилцахын үлдэгдлийг улирал, жилийн эцэст баталгаажуулаагүйн улмаас 80,738.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Улирал, жилийн эцэст тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Харилцахын үлдэгдлийг улирал, жилийн эцэст баталгаажуулаагүй	1	80,738.5					1	80,738.5				
Дүн	1	80,738.5						80,738.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэнд дансанд мэдээлбэл зохих 159 мэдээллээс 150 мэдээллийг хугацаандаа, 9 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn